

Баянгол дүүрэг "Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага" Түргэвчилсэн судалгаа

2022 оны 6-р сар



© В.Эрдэнэ

Агуулга

Удиртгал ба аргачлал	1
Мэдээллийн дүн шинжилгээ.....	2
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм.....	2
1.2 Ирсэн иргэд.....	3
1.3 Явсан иргэд.....	3
1.4 Хөдөлмөр эрхлэлт.....	4
1.5 Санхүүгийн нөхцөл байдал.....	5
1.6 Тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал.....	6
1.7 Үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц.....	10
1.8 Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж.....	14
1.9 Тээвэр, замын хөдөлгөөний нөхцөл байдал.....	15
1.10 Хүүхэд болон боловсрол.....	16

Удиртгал ба аргачлал

Удиртгал

Дүүргийн түвшний энэхүү тайланд 2022 оны 3-р сард Улаанбаатар хотын хэмжээнд хүн ам, шилжилт хөдөлгөөн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шуурхай үнэлгээнд тусгагдсан үндсэн болоод сэдэвчилсэн бүх чиглэлийн тойм мэдээллийг багтаасан болно.

Энэхүү тайлан нь Баянгол дүүргийн хэмжээнд найман үндсэн сэдвийг хамарсан судалгааг багтаасан; тухайлбал, хүн амын суурь тоон үзүүлэлт, хүн ам зүй, ирсэн болон явсан иргэд (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд ба аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хүүхэд болон боловсрол гэх мэт. Мэдээллийг дүүргийн нутаг дэвсгэр, хүний нөөц, засаг захиргааны нэгжийн харилцааны талаарх мэдлэг өндөртэй мэдээлэл нэгтгэгчид болох хэсгийн ахлагч нартай ярилцлага хийх замаар олж авсан.

Энэхүү судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын дэлгэрэнгүй тайлангаас авч үзнэ үү.

Аргачлал

Энэхүү тайланд ОУШХБ-ын Шилжих хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн нэгжээс боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараас мэдээллийг цуглуулав. Хэсгийн ахлагч нар иргэдтэй ярилцах, ажиглалт хийх болон өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан, харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөсөн. Хэсгийн ахлагч нарыг хүн амын суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхэд ба боловсрол гэсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны асуулгыг бөглөхийг хүссэн юм.

Хэсгийн ахлагч нар Кобо программ хамгамжаар дамжуулан тоон мэдээллийг гар утас эсвэл таблет, компьютер ашиглан бөглөж илгээсэн. Хэсгийн ахлагч нарыг ДТМ судалгааны аргачлал, судалгааны асуулга, түүнийг нөхөхтэй холбоотой танхимын сургалтад бүрэн хамруулсан. Түүнчлэн ДТМ-ийн баг мэдээлэл цуглуулах явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.


Өгөгдөл оруулах үйл явц албан ёсоор хаагдмагц ДТМ-ийн баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд өгөгдөл оруулахад гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг хийсэн. Өгөгдөлтэй холбоотой аливаа асуудал илэрсэн тохиолдолд ДТМ-ийн баг тодруулга авахаар хэсгийн ахлагч нартай утсаар холбогдож тоон мэдээллийг тодруулж, баталгаажуулсан байна. Бүх хяналт, шалгалтыг хийж дууссаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Бүх судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж, дараа нь дүүргийн болон хотын хэмжээнд нэгтгэн дүгнэв. Иймээс дүүрэг, хотын түвшинд энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд ч авах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

Хязгаарлагдмал байдал, судалгааны аргачлалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын хэмжээний нэгдсэн тайлангаас үзнэ үү.




1. Мэдээллийн дүн шинжилгээ - Баянгол дүүрэг

1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм



Хүн ам зүй (эзлэх хувь)




Үнэлгээ хийх үед (2022 оны гуравдугаар сар) Баянгол дүүрэгт 238,067 иргэн буюу 61,449 өрх бүртгэгдсэн нь Улаанбаатар хотын хүн амын 16 хувийг эзэлж байгаа бөгөөд хүн амын тоогоороо гуравдугаарт орж байна. Нийт хүн амын 46 хувь нь эрэгтэй, 54 хувь нь эмэгтэй байна. Хүн амын 32 хувь нь насанд хүрээгүй хүүхэд гэж бүртгэгдсэн бол: 10 хувь нь 0-5 нас, 21 хувь нь 6-17 насны хүүхдүүд байна. Хүн амын 62 хувийг 18-65 насны насанд хүрэгчид, 6 хувь нь өндөр настан (65-аас дээш насныхан) эзэлж байна.

Нийтдээ 3,991 хүн архаг эсвэл хүнд өвчтэй (хүн амын 1.7%), 2,732 эмэгтэй жирэмсэн (эмэгтэйчүүдийн 2,1%) байна.

Баянгол дүүрэг нь 25 хороо, 254 хэсэгтэй. 3-р хороо нь хамгийн их хүн амтай бөгөөд нийт дүүргийн арван хүн тутмын нэг нь амьдардаг, дараа нь 6-р хороо нийт иргэдийн 7 хувь нь амьдардаг гэж бүртгэгджээ.


Хүн ам зүйн тойм хүйсээр, хороогоор (эзлэх хувь)



1.2 Ирсэн иргэд²

2021 онд Баянгол дүүрэгт нийт 5,355 өрх буюу 14,884 иргэн ирсэн байна. 2021 онд Улаанбаатар хотод нийт ирсэн иргэдийн 12,4 хувь нь Баянгол дүүрэгт буюу 3-р хороонд (11%) хамгийн өндөр хувьтай ирсэн байна. Энэ дүүрэгт ирсэн гол шалтгаан нь боловсрол (32%), гэр бүлийн шалтгаан (25%), эдийн засгийн шалтгаан (13%) байна.


Ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)




1.3 Явсан иргэд

2021 онд Баянгол дүүргээс нийт 2,710 өрх буюу 8,163 иргэн явсан. 2021 онд Улаанбаатар хотоос нийт явсан хөдөлгөөний 9.4 хувь нь Баянгол дүүргээс бусад дүүрэг, хөдөө орон нутаг руу явсан байна. Хамгийн өндөр хувь нь 3-р хороо (11%), 6-р хороо (8%), 18-р хороо (7%) бүртгэгдсэн байна. Ерөнхийдөө энэ дүүргээс явах болсон хамгийн гол шалтгаан нь гэр бүлийн шалтгаан (26%) байв.

Явсан иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)




Ирсэн, явсан үндсэн шалтгаанууд (эзлэх хувь)




² Ирсэн иргэд гэдэг нь Улаанбаатар хотын дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран Улаанбаатар хотын аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ. Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль нэг байршлаас явсан эсэхийг үл хамааран явсан иргэн, айл өрхийг хэлнэ.

1.4 Хөдөлмөр эрхлэлтийн байдал


Баянгол дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зонхилох салбар нь бөөний болон жижиглэнгийн худалдаа (хэсгүүдийн 44 хувьд мэдээлсэн), бусад (12%), барилга (8%), боловсролын салбар (7%) байна. Харин Баянгол дүүргийн хамгийн олон хүн амтай хороо болох 3-р хорооны хөдөлмөр эрхлэлтийн зонхилох салбар (24,947 хувь хүн; дүүргийн хүн амын 10%) нь уул уурхай, олборлох болон бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 40 хувьд бүртгэгдсэн байна. Бөөний болон жижиглэнгийн худалдаа 13-р хороо (хэсэгүүдийн 100%), 14-р хороо (80%), 6-р хороо, 16-р хороо (хоёулаа 75%-нд хамгийн ихээр бүртгэгдсэн байв. Бөөний болон жижиглэнгийн худалдаа нь хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар гэж хамгийн их бүртгэгдсэн 13-р хороонд 103,461 иргэн (дүүргийн хүн амын 43%) амьдардаг. Баянгол дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн гурав дахь үндсэн салбар болох барилгын салбар нь 2-р хороонд хамгийн их бүртгэгдсэн бөгөөд энэ нь нийт хэсгийн гуравны нэгийг эзэлж байна.




Хөдөлмөр эрхлээгүй хүн ам (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь, хороогоор (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл (хэсгийн эзлэх хувь)



Баянгол дүүргийн хэмжээнд 18-64 насны 34,822 иргэн хөдөлмөр эрхлээгүй байгаа нь насанд хүрсэн хүн амын 23 хувийг эзэлж байна. Энэ дүүрэгт хөдөлмөр эрхлээгүй хүн амын түвшин Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн бага буюу үндсэн дунджаас долоон хувиар бага (30%) байна. Энэ нь ялангуяа Баянгол дүүрэг нь Улаанбаатар хотын хүн амын 16 хувийг эзэлдэг, хүн амын тоогоор гуравдугаарт ордог дүүрэг гэдгийг тооцвол нэлээд ач холбогдолтой мэдээлэл гэж харагдаж байна. Баянгол дүүрэгт ажлын байр хангалтгүй байгаа нь бөөний болон жижиглэнгийн худалдаа нь хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (хотын түвшний дундаж 29%-тай харьцуулахад 44%) гэдэгтэй холбоотой байх магадлалтай юм. 6-р хороонд (0%) хамгийн бага буюу насанд хүрсэн 10,571 хүн хөдөлмөр эрхэлдэг; 22-р хороо (5%), 9-р хороо (7%) байна. Эдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны 20,111 байгаагаас 19,564 нь хөдөлмөр эрхэлж байгаа гэж мэдээлсэн байна. Харин эсрэгээрээ 13-р хороо (49%), 8-р хороо (46%), 1-р хороонд (43%) хөдөлмөр эрхлээгүй хүн амын түвшин хамгийн өндөр байна. Эдгээр гурван хороо нийлээд хөдөлмөрийн насны 18,252 иргэний 8,306 нь ажилгүй байна гэсэн мэдээлэл байна.

Баянгол дүүргийн хэмжээнд нийт хүн амын 74 хувьд хувийн хэвшил, 13 хувьд төрийн байгууллага, 11 хувьд хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 1 хувьд өдрөөр цалинждаг хөдөлмөр эрхэлдэг гэж мэдээлсэн байна. 16, 19-р хороонд хувийн хэвшил (хоёулаа 100%), харин 14-р хороонд төрийн захиргаа, (80%) давамгайлж байна. Баянгол дүүрэгт хувийн хэвшлийн нөлөөллийн түвшин өндөр байгаа нь (нийслэлийн дундаж хэмжээ 68 хувиас 6 хувиар илүү) хөдөлмөр эрхлээгүй хүн ам бага байгаатай холбоотой байж болох юм.


1.5 Санхүүгийн нөхцөл байдал

Энэ хэсэгт орлогын бууралт болон хүнсэнд зарцуулах зардлын бууралттай холбоотой асуудлаар мэдээлэл нэгтгэгчдийн ажиглалтыг авч үзэх замаар төлбөрийн чадварыг судалсан болно.

Нийт Баянгол дүүргийн 18 хувьд нь мэдээлэл нэгтгэгчид мэдээлэл цуглуулахаас дөрвөн долоо хоногийн өмнө айл өрхүүд хангалттай хоол хүнс хэрэглэхгүй байгаа талаар санаа зовниж байгаагаа мэдээлсэн нь нийт 37,613 хүн амыг хамарч байгаа юм. Энэ үзүүлэлт нь нийслэлийн дундаж (29%) хэмжээнээс 11 хувиар бага үзүүлэлт юм. 22-р хороо хамгийн эмзэг байгаа бөгөөд хэсгүүдийн 50 хувьд нь мэдээлэл цуглуулагчид идэх хоол хүрэлцэхгүй байна гэсэн байна.

Хэсгүүдийн 22 хувь хувьд нь мэдээлэл цуглуулахаас дөрвөн долоо хоногийн өмнө айл өрхүүд хүнсний хэрэглээгээ багасгасан тухай сонссон гэж мэдээлсэн нь нийт 50,086 хүн амыг хамарч байна. Энэ үзүүлэлт нь Улаанбаатар хотын хэмжээнд дундаж 34 хувиас 12 хувиар бага юм. 22, 25 дугаар хороодод хамгийн өндөр байгаа бөгөөд хэсгийн 50 хувьд нь мэдээлэл нэгтгэгчид айл өрхүүд хүнсний зардлаа бууруулж байгаа тухай сонссон байна.


Сүүлийн 4 долоо хоногт орлого нь буурсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



Баянгол дүүргийн нутаг дэвсгэрийн 85 хувьд нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд бараг хэн ч буюу нийт оршин суугчдын талаас бага хувийн орлого буурсан гэж мэдээлсэн байна. Хэсгүүдийн 15 хувь нь оршин суугчдын тал буюу талаас илүү орлогоо алдсан байна. Энэ нь 39,661 хүн амыг хамраад байна. Баянгол дүүргийн 93 хувьд нь мэдээлэл нэгтгэхээс өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд бараг хэн ч буюу оршин суугчдын талаас бага хувь нь бүх орлогоо алдсан гэж мэдээлсэн байна. Гэсэн хэдий ч, хэсгүүдийн долоон хувьд оршин суугчдын тал буюу талаас илүү хувь нь бүх орлогоо алдсан (17,006 хүн) гэж мэдээлсэн байна.

Хүнсний аюулгүй байдал (хэсгийн эзлэх хувь)


Хүнсний хэрэглээ хангалтгүй байгаад санаа зовних



Хүнсний хэрэглээгээ багасгасан




Сүүлийн 4 долоо хоногт бүх орлогоо алдсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



1.6 Тулгамдаж буй асуудал болон аюулгүй байдал

Баянгол дүүргийн хэмжээнд хамгийн тулгамдсан асуудал бол санхүү, эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотой байв. Хамгийн их мэдээлсэн тулгамдаж буй асуудал бол орлого хангалтгүй (хэсгүүдийн 55 хувьд мэдээлсэн), дараа нь хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь өндөр (16%), өр, зээл (13%) -тэй иргэд их байна гэж мэдээлсэн байна. Орлого хангалтгүй гэсэн санаа зовнил 12-р хороонд хамгийн их бүртгэгдсэн бөгөөд энэ нь бүх хэсгүүдэд мэдээлэгдсэн байна.

Тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




Баянгол дүүргийн хэмжээнд иргэдэд хамгийн хүртээмжгүй гэж үзсэн үйлчилгээ нь авто машины зогсоолын хүртээмж (29%), амьжиргаа, ажлын байр, орлогын эх үүсвэр бий болгох боломж дутмаг (27%), боловсролын хүртээмж муу (16%) байна. 14-р хорооны бүх хэсгүүдийн хувьд авто машины зогсоолын асуудал нь нэн тэргүүнд анхаарал хандуулах асуудал байсан бол 18-р хорооны 73 хувь нь амьжиргаа, ажлын байр, орлогын эх үүсвэр бий болгох боломжыг нэмэгдүүлэх гэсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй гол бэрхшээл нь гудамж, цэцэрлэгт хүрээлэн, барилга байгууламжид аюулгүй нэвтрэх дэд бүтэц дутмаг (57%), дараа нь тусгай зориулалтын эмнэлгийн тусламж үйлчилгээ дутмаг (19%) гэж мэдээлсэн байна.



Хүндрэлтэй байдаг үйлчилгээ (хэсгийн эзлэх хувь)




Аюулгүй байдал, хороогоор Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн



Аюулгүй байдлыг хөндсөн асуудал гарсан эсэх (хэсгийн эзлэх хувь)


Аюулгүй байдлыг хөндсөн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

УС

Усны хэрэглээгүй байгаа хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Устай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Цахилгааны хэрэглээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Цахилгааны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ХООЛ, ХҮНС

Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ОРОН БАЙР

Орон байрны хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Орон байртай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



1.7 Дэд бүтэц, үйлчилгээ



ХҮНСНИЙ БУС ЗҮЙЛС




ИНТЕРНЭТ



ЭРҮҮЛ МЭНД



УХААЛАГ УТАС



1.8 Ногоон байгууламж


Мэдээлэл нэгтгэгчээс өөрийн хэсгийн нутаг дэвсгэр дээрх ногоон байгууламж цэцэрлэгт хүрээлэнгийн чанарыг нэгээс тав хүртэл, (нэг нь маш муу, тав нь маш сайн) оноогоор үнэлэхийг хүссэн. Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар 14-р хороонд хамгийн сайн (3.6), 9-р хороонд хамгийн муу (1.6). Хувийн хэвшлийн ногоон байгууламжийн чанар мөн 14-р хороонд хамгийн сайн (3.6), 9-р хороонд (1.2) маш муу байв. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн чанар дахин 14-р хороонд хамгийн сайн (3.8), харин 9, 11-р хороонд (1.6) хамгийн муу байна.

Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар (хэсгийн эзлэх хувь)


Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш

	Өрхийн ногоон байгууламж	Хувийн хэвшлийн ногоон байгууламж	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж
Хороо #1	2.8	3.1	3.1
Хороо #2	2.2	2.3	2.3
Хороо #3	2.9	2.8	2.7
Хороо #4	2.9	2.6	2.7
Хороо #5	1.9	1.9	2.0
Хороо #6	2.6	2.5	2.6
Хороо #7	2.3	2.1	2.0
Хороо #8	2.9	3.0	2.8
Хороо #9	1.6	1.2	1.6
Хороо #10	3.0	2.9	2.7
Хороо #11	1.8	1.7	1.6
Хороо #12	2.3	2.4	2.5
Хороо #13	3.4	3.2	3.4
Хороо #14	3.6	3.6	3.8
Хороо #15	3.0	2.7	2.8
Хороо #16	2.3	2.4	2.1
Хороо #17	2.3	1.5	1.9
Хороо #18	2.5	2.4	2.5
Хороо #19	2.0	2.0	1.9
Хороо #20	2.5	2.8	2.3
Хороо #21	2.2	1.8	1.8
Хороо #22	2.5	2.0	1.9
Хороо #23	2.7	2.4	2.6
Хороо #24	2.4	2.0	2.0
Хороо #25	2.3	2.1	2.1


Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




1.9 Зам тээвэр ба хөдөлгөөн


Хувийн тээврийн хэрэгсэлгүй өрх (хэсгийн эзлэх хувь)



Тээврийн үндсэн аргууд (хэсгийн эзлэх хувь)



Замын хөдөлгөөнтэй холбоотой үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Баянгол дүүрэгт замын хөдөлгөөнтэй холбоотой гарч болзошгүй бүх асуудал бүртгэгдсэн бөгөөд тус дүүргийн 50 хувьд хамгийн түгээмэл зорчих арга нь авто машин гэж мэдээлжээ. Хамгийн их бүртгэгдсэн тулгамдсан асуудал бол авто машины зогсоол дутмаг (хэсэгүүдийн 33 хувьд бүртгэгдсэн), ачаалал хэт ихтэй (22), хүүхэд тоглох талбай дутмаг (17%) зэрэг асуудлууд байна. Зогсоолын хүрэлцээ муу байгаа нь 13-р хороонд (хэсэгүүдийн 80 хувьд нь) гол бэрхшээл гэж мэдээлсэн юм.



© У. Одбаяр

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх; шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг болно.


Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Судалгааны аргачлал, арга зүй, дүн шинжилгээ, тайланг загварчлах ажлыг ОУШХБ-ын ДТМ хариуцсан ОУ-ын зөвлөх Витторио Бруни, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтох, туслах ажилтан Болор-эрдэний Маналцогзолын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгыг ОУШХБ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн удирдлагуудын техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

1.10 Хүүхэд ба боловсрол

Баянгол дүүргийн хэмжээнд 0-5 насны 8,728 хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй (тухайн насны хүн амын 35%), 6-17 насны 1587 хүүхэд (тухайн насны хүн амын 3%) цэцэрлэгт хамрагдаагүй байна. Баянгол дүүргийн 0-5 насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин нь нийслэлд гуравдугаарт орсон бөгөөд нийслэлийн дунджаас 5 хувиар өндөр байна. 0-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин хамгийн өндөр хувь нь 3-р хороонд (75%) байна. 15-р хороонд 6-17 насны хүүхдүүдийн боловсролд хамрагдаагүй түвшин маш өндөр буюу 31 хувьтай байна.

Хүүхдүүдийн ерөнхий нөхцөл байдлыг илүү өргөн хүрээнд судлахын тулд мэдээлэл нэгтгэгчээс хүүхдүүдэд тулгардаг үндсэн асуудал өөрсдийн хэсгийн нутаг дэвсгэр дээр хэр байгаа талаар асуусан. Баянгол дүүргийн хэсгүүдийн 38 хувь нь боловсролтой холбоотой ямар ч асуудал байхгүй гэж хариулсан бол 15 хувь нь сургууль хоорондын зай хэт хол, 20 хувь нь сургуулийн хүрэлцээ муу гэж хариулжээ. Дүүргийн хэмжээнд хүүхдүүдтэй холбоотой хамгийн их бүртгэгдсэн хоёр асуудал бол хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх клуб, спортын төв, дугуйлан дутмаг (хэсгүүдийн 34%) болон сургууль хүртэлх зай хэт хол (18%) байсан юм.

Боловсролтой холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Сургуульд хамрагдаагүй хүүхдүүд (хэсгийн эзлэх хувь)

0-5 насны цэцэрлэгт хамрагдаагүй хүүхэд



6-17 насны сургуульд хамрагдаагүй хүүхэд



Хүүхдэд тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)

